

ХАРХОРУМ ХОТЫН АРХЕОЛОГИЙН

СУДАЛГААНЫ ТОЙМ

Их Монгол улсын нийслэл Хархорум хотын туурь чухам хаана байдгийг 19-р зууны 20-оод оноос эрдэмтэд судлаачид сонирхон судалж, олж тогтоохыг зорьсоор иржээ.

Энэ асуудлыг Францын Абель Ремюза, Д.Оссон, Оросын эрдэмтэн Н.Я.Бичирун зэрэг эрдэмтдийн сурвалж бичгийн мэдээнд тулгуурласан судалгааны дүнд Хархорум хот оршин байсан гэх хэд хэдэн газрыг санал болгож байсан юм.Түүхийн судалгааны мэдээ баримтаар тодруулж гаргасан эдгээр санал дүгнэлтийн үнэн зөвийг нягтлах археологийн хайгуул шинжилгээний ажил 19-р зууны сүүл буюу 1870-аад оноос эхэлсэн байна. Тухайлбал Хархорум хотын ор туурийг эрж олох зорилго агуулан эртний түүх дурсгалаар нэн баялаг Орхоны хөндийд археологийн хайгуул судалгаа анх гүйцэтгэсэн хүн бол Оросын эрдэмтэн И.Падерин юм. Тэрээр тухайн үед мэдэгдээд байсан Хархорумын тухай мэдээ баримтуудыг газар дээр нь шалган тогтоохоор Улиастай хүрэх аян замд гарчээ. Энэ аяны замдаа Орхоны хөндийгөөр дайран Харбалгас, Харбухын балгас зэрэг эртний дурсгалт хотуудыг үзэж, эдгээрийн түүх, хэн үүсгэн барьсан болох талаар нутгийн ард түмний ярьж хэлцдэг домог яриа тэргүүтнийг тэмдэглэн авч, эртний жуулчдын тэмдэглэлтэй харьцуулан үзэж түүхэн үнэнийг тогтоохыг зорьжээ. Тэгэхдээ тэрээр Харбалгасыг нутгийнхан “Хар хэрэм” хэмээн нэрлэдгийг анхааралдаа авч, энэ нь Хархорум хотын нэрийн сунжирсан дуудлага хэмээн үзэж Орхоны хөндийд байх энэхүү сүр жавхлантай эртний хотын үлдэгдэл нь Их Монгол улсын нийслэл Хархорум хотын ор үлдэц мөн гэж үзсэн байна. И.Падерин хэдийгээр Хархорумын оршин буй газрыг олж тогтоож хараахан чадаагүй ч Монголын төв нутагт буй эртний түүх, соёлын алдарт дурсгалууд, Тухайлбал Харбалгас, Хадаасангийн балгас зэргийг археологийн үүднээс анх тодорхойлон бичиж олонд сонордуулж байсан судлаач болно.

Монголын түүхийн нэн чухал сурвалжийн нэг болох “Эрдэний эрих” дэх Эрдэнэ Зуу хийдийг үүсгэн байгуулсан тухай мэдээг нарийвчлан шинжсэний дүнд нэрт монголч эрдэмтэн А.М.Позднеев уг хийдийн дэргэдэх эртний туурь нь даруй Их Монгол улсын нийслэл хотын үлдэгдэл мөн гэх саналыг 1888 онд дэвшүүлсэн

нь цаашдаа археологийн судалгаа болон нутгийн ард түмний дунд хадгалагдаж үлдсэн аман домог тэргүүтнээр нотлогдсон билээ.

1889 онд Монголын орны төв нутаг Орхоны хөндийгөөр голлон судалгаа хийсэн эрдэмтэн Н.М.Ядринцев Эрдэнэ Зуу хийдийн дэргэд орших эртний хотын туурийг үзэн сонирхож, тэндээс авчирсан гэрэлт хөшөө зэрэг эртний дурсгалт зүйл олноороо Эрдэнэ Зуу хийдийн дотор хадгалагдаж байгааг гол баримт болгон Их Монгол улсын нийслэл чухам энд оршин байсныг газар дээр нь нягтлан шалгаж тодруулсан байна. Эл шинжилгээний ангийн мөрөөр ирж ажилласан **“Орхоны шинжилгээний анги”** нь Монгол орны төв нутагт байх эртний олон хот сууриныг бүртгэн тэмдэглэж гар болон гэрэл зураг, дэвсгэр зураг үйлдэн судалгааны эх үндсийг тавьсан билээ.

Түүний дараа 1891 онд Оросын Эзэн Хааны ШУА-ийн томилолтоор академич В.В.Радловаар толгойлуулан ирсэн **“Орхоны шинжилгээний анги”** Монголын төв нутаг Орхон, Туулын сав дагуу ажиллахдаа эндхийн түүх дурсгалт олон газрыг үзэж зураглан тэмдэглэж авсны дотор Хархорумын үлдэц нурангийг нарийвчлан шинжиж, газрын зургийн мэргэжилтэн ахмад Л.И.Шеголов Хархорумын туурь болон Эрдэнэ Зуу хийдийн хашаанд байгаа эртний Хархорумын тууриас авчран заримыг нь сул тавьж, заримыг нь сүм, хэрмийн дор суурилуулж суулгасан бичигт хөшөөний хугархай, баганы суурь, тээрмийн болон барилгын довжооны засмал чулууд зэрэг хуучны олон дурсгалыг үзэж хэв хуулга авч нийтлүүлсэн юм.

Австрийн байгаль судлаач, угсаатны зүйч Ханс Ледер Монгол нутгаар аялан явж судалгаа хийсэн ба Эрдэнэ Зуу хийдийн эргэн тойронд эдгэрч бүдгэрсэн усжуулалтын сувгийн ор мөр бүхий хуучин хотын туурь байхыг ажиглаж мэдсэнээс гадна тэндээс зарим нэг бичээстэй чулуудыг хайж олсон байна.

1948-1949 оны хооронд Төв Азийн түүх соёлын судлаач нэрт эрдэмтэн С.В.Киселев, манай улсын ууган археологич Х.Пэрлээ нарын удирдлагаар Монгол-Зөвлөлийн хамтарсан шинжилгээний анги Хархорум хотод дорвитой томхон малтлагын ажил гүйцэтгэж эрдэм шинжилгээний үнэ цэнтэй олдвор хэрэглэгдэхүүн цуглуулан, дурсгалын холбогдох он цаг, үүрэг зориулалтыг нягтлан тодорхойлж манай түүхийн шинжлэх ухааныг арвин баялаг олдвор, шинэ сэргэг мэдээ баримтаар баяжуулсан билээ. Тус шинжилгээний ажлын үр дүнд Эрдэнэ Зуу хийдийн дэргэд оршиж буй эртний хотын үлдэгдэл нь Их Монгол улсын нийслэл

Хархорумын туурь болохыг анх удаа археологийн судалгааны биет баримтаар нотлон тогтоож, энэ хот нь зөвхөн улс төр, засаг захиргааны төв төдийгүй тухайн үеийн үйлдвэр, худалдааны төв хот байсныг нотлон харуулжээ. Хотын төв хэсэгдэх худалдаа арилжаа эрчимтэй хөгжиж байсныг харуулах арвин баялаг хэрэглэгдэхүүн олджээ.

1976-1986 онд Н.Сэр-Оджавын удирдсан Хархорумын шинжилгээний анги Их Монгол улсын нийслэл Хархорум болон ХарХул хааны балгасанд малтлага судалгааны ажил гүйцэтгэсэн юм. Тус шинжилгээний анги нь Хархорум хотын дүүрэгт Монголчуудын болон лалын шашинт иргэдийн булш оршуулгыг малтан судалснаар Их Монгол улсын нийслэл хотод янз бүрийн шашин чөлөөтэй дэлгэрэн хөгжиж, өөр өөр угсаа гаралт иргэд эв найртай амьдран сууж байсан тухай өгүүлдэг сурвалж бичгийн мэдээг биет баримтаар нотолжээ.

1995-1996 онд ЮНЕСКО-ийн ивээл дор зохиогдсон Хархорум хотын туурийг хадгалан хамгаалах шинжилгээний анги нь Монголын эртний нийслэлийн судалгаанд нэн чухал үүрэг гүйцэтгэсэн. Монгол-Японы судлаачид хамтран гүйцэтгэсэн энэхүү төсөл нь эртний нийслэлийн дэвсгэр талбайн хотгор гүдгэрийн болон археологийн нарийвчилсан дэвсгэр зураг үйлдэж, хамгаалалтын бүс тогтоон, энэ бүсийг тойруулан хашаагаар хүрээлж тодорхой цэгүүдэд танилцуулгын самбар босгосон нь эртний нийслэлийн дэвсгэр нутгийг гадны аливаа нөлөөллөөс хамгаалахад чиглэсэн, эрдэмтэн судлаачдын олон жилийн хүсэл мөрөөдлийг гүйцээсэн бодит ажил болсон билээ. Түүнчлэн тус шинжилгээний анги нь Хархорум хотын ойр орчимд буй түүх соёлын холбоо бүхий өөр бусад хот хэрмийн үлдэгдлийг хамруулан судалсны тоонд Мэлхийт орд буюу Тогос орд, Захын булаг, Баянголын туурь, Хөгшин Орхоны дөрвөлжин, Хар бондгор зэрэг дурсгалыг дурдах хэрэгтэй. Энэ нь Монголын их хаад Хархорум хотод байнга оршин сууж байгаагүй, улирлын шинжтэй нүүдэл хийж тусгай тусгай ордуудад сууж байсан тухай бичмэл сурвалжийн мэдээг археологийн биет олдвороор нотлох боломж бүрдсэн байна.

1999 оноос Хархорум хотын дэвсгэр талбайд үйл ажиллагаа эхлүүлсэн Монгол-Германы хамтарсан **“Хархорум”** төслийн судалгааны анги энд тогтмол ажиллан эртний хотын малтлага судалгааг шинэ төвшинд үргэлжлүүлээ. Энэхүү хамтарсан судалгаа нь малтан илрүүлсэн эд өлгийн зүйлсийг нөхөн сэргээж анхны хэлбэр дүрсийг нь тодруулах, үл хөдлөх олдвор зүйлсийг газар дээр нь бэхжүүлэн хадгалах, олдворын он цагийг тодорхойлох, газар доор байгаа барилга



байгууламжийг урьдчилан тодруулах зэрэгт байгалийн ухааны дэвшилтэт аргуудыг өргөн хэрэглэсэн. Эдгээр бичмэл сурвалжийн мэдээг археологийн биет олдвортой илүү нягт нямбай харьцуулан судалсны дүнд өмнөх үеийн судалгааны зарим эндүү ташаа ойлголтыг засч залруулан, түүхийн үнэнийг бодит үнэнээр тогтоох боломжийг бүрдүүлж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 1997 оны 12 сарын 15-ны өдрийн 241 тоот тогтоолоор Монголын эртний нийслэл Хархорум хотын туурийн хамгаалалтын бүсийг 9.69 кв м байхаар тогтоожээ.



ХАРХОРУМ ХОТЫН ХАМГААЛАЛТЫН БҮС

МОНГОЛ УЛСЫН ЗЭЭСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ
1997 ОНЫ 12 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР
ДУГААР 241



МАСШТАБ 1:20000

Хархорум хотын тууриас илэрсэн томоохоны олворууд:

Хархорум хотын туурьд явуулсан археологийн малтлагаар илрүүлсэн дараах үнэ цэнт олдворуудыг Дэлхийн өвийн **"Хархорум"** музейн үзүүлэгийн танхимуудад дэлгэн тавьж аялагч жуулчид, олон нийтэд үзүүлж сурталчлан таниулж байна.



Шавар эдлэл шатаах зуух

Монгол-Германы хамтарсан Хархорум шинжилгээний анги 2000 онд Хархорум хотын хааны ордны дүүрэгт хийсэн малталтаараа гадаад ирмэг 4,2-5,25 метр голчтой 0,71,5 метр өндөр зууван дугуй хэлбэрийн 4 зуухыг нээн илрүүлсэн.

13-р зууны үед барилгын материал шавар вааран чимэглэл, тоосго зэргийг шатаан боловсруулж байсан эдгээр зуухнууд нь дундад зууны Монголын нийслэл хотод хөгжиж байсан үйлдвэрлэлийн арга ажиллагааг бодитойгоор харуулах нэн үнэт

дурсгал болсон юм.

Халаалтын систем



Монгол Германы хамтарсан экспедицийн 2004 оны малтлагаар хотын төв хэсгээс буюу гар урчуудын дүүргээс шалны халаалтын систем илэрсэн. Уг халаалтын системийн ханзны сувгийг хийхдээ түүхий тоосгыг нимгэн талаар нь зэрэгцүүлэн өрж дээрээс нь хавтгай чулуугаар тагласан байжээ. Урт

удаан хугацаанд галлаж халуун утаа гүйлгэж байснаас дотор тал нь бараг шатсан байв.



ПЛИТА ШАЛ

2003 онд Монгол Германы хамтарсан Хархорум экспедици Буддын сүмийн хэсэгт малтлага хийж нэгэн байгууламжийн цайвар ногоон өнгийн хавтан шал илрүүлсэн.



ШААЗАН АРСЛАН

Цаг хугацааны хувьд Сүн улс, Юань гүрний үед холбогдоно. Арсланг нарийн ширхэгтэй цагаан шавраар хийж, цэнхэр туяа бүхий тунгалаг паалан гүйлгэжээ. Арслангийн бэлгэдэл нь баруун Азиас нэвтэрсэн бөгөөд тэр нь сүр хүч, аюул осол, муу зүйлээс сэргийлэн хамгаалах сахиус амьтан ажээ.



ДӨРВӨЛЖИН ҮСЭГТЭЙ ТАМГА

Зэсийн хайлшаар цутгаж хийсэн албаны тамга. Тамганы уланд дөрвөлжин бичгээр “**Сангийн яамны сайдын тамгалах тамга**”, ар талд “**Аюуширидар хааны төр барьсны хоёрдугаар оны гуравдугаар сард олгосон**” хэмээн хятад ханзаар сийлэн бичжээ.

АЛТАН БУГУЙВЧ

Хоёр ширхэг нимгэн хавтгай алтыг хэвэнд хөөн цохиж хээ гаргаад, нугасаар холбон хийжээ. Бугуйвч дээр нисэж буй галт шувуу бадам цэцгийн дэлбээ мэт сүйхэлжин хэлбэртэй хээгээр хүрээлж, хоёр талд нь зээбад дүрсэлсэн. Галт шувуу нь үлгэр домгийн амьтан бөгөөд сэргийлэн хамгаалах, саар мууг хаахын бэлгэдэл юм.



Бугуйвчийн дээд, доод ирмэгийн дагуу эгнүүлэн шигтгээ суулгах сууриудыг гагнаж тогтоожээ.

БУГУЙВЧНЫ ХЭВ



Галт шувуу, зээбадын дүрслэлтэй хүрэл хэв. Энэхүү хэвэн дээр бугуйвч хийх төмөрлөгөө тавьж ховилдон цохиж бугуйвчны дүрслэл гаргадаг байжээ. Хэвний дүрслэл алтан бугуйвчны дүрслэлтэй тохирч байгаа нь тус бугуйвчны хэв мөн болохыг илтгэнэ.

ШААЗАН ЭДЛЭЛ

Хархорумаас олдсон шаазан эдлэлүүд ихэвчлэн лунчюань, дин, чинбай, яожоу, цижоу, жүнь хийцийнх байна. Он цагийн хувьд Сүн улс /960-1279/, Юань гүрний /1272-1368/ үед холбогдоно. Зарим нарийн ширхэгтэй шавраар хийсэн сайн чанарын шаазанг Хятадаас оруулж ирдэг байсан бол арай бүдүүн ширхэг бүхий паалантай шавар эдлэлийг орон нутагт үйлдвэрлэдэг байсан байна. Эдгээрээс чамин нарийн хийцтэй найман дэлбээ бүхий цэцгэн хэлбэртэй цагаан шаазан аяга, тогоруу нугас, цэцэг, навчин хээгээр чимсэн хөх цагаан таваг зэрэг нь ховорт тооцогдох үнэ цэнт дурсгал юм.



Ном зүй

1. Д.Баяр. монголын дундад зууны археологийн судалгаа II боть. Улаанбаатар 2013 он
2. Н.Доржсүрэн, Археологийн судалгаа эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл, Улаанбаатар 2003 он
3. Б.Дэжидмаа, Б.Мөнхзул, Ж.Цамбагарав, Б.Цэцэгмаа, О.Энхбилгүүн Хархорум музейн үзүүллэгийн товч тайлбар. Хархорин 2014
4. Д. Цэвээндорж, Н.Уртнасан. Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх

5. ШУА, Археологийн хүрээлэн. Монголын археологи-2014. Улаанбаатар 2015он
6. У.Эрдэнэбат. Монголын эртний нийслэл Хархорум, Улаанбаатар 2018 он
7. Цахим эх сурвалж <http://www.kharakhorummuseum.mn/>

Ил музей - Цогт Их Асар сүм



Ил музей

Герман-Монголын судлаачдын Хархорум хотод хийсэн археологийн малтлагын нэг чухал үр дүн бол олон жилийн турш Өгэдэйн хааны байгуулсан “Түмэн амгалант ордон” хэмээн үзэж байсан том барилгын гол танхимыг бүх талбайгаар малтан ил гаргаж, түүний бүтэц, зохион байгуулалт, он цагийг тогтоосон явдал юм. Олдворын цогц байдлын шинжилгээг дүгнэж үзэхэд, шороо үелүүлэн дэлдэж хийсэн 2м орчим өндөр довжоон дээр байгуулсан 38х38м орчим хэмжээтэй, 7х7 жигүүртэй, 8х8 эгнээ багана буюу нийтдээ 64 баганатай, төв суурь нь тэг дөрвөлжин хэлбэртэй барилга байжээ.



Буддын сүмийн археологийн малтлага

2014 оны археологийн судалгаагаар барилгын сууриас дөрвөн шүншигийг илрүүлэн олсон бөгөөд шүншигт тариа будаа, төрөл бүрийн жимс, алтан утастай торгонд боодолтой “есэн эрдэнэ” (Монгол гүрний их хаадын алтан зоос хоёр ширхэг, шүр, сувд, оюу) оруулж том вааран саванд хийж, амсрыг шавар тагаар таглаж тавьжээ.

Малтлагаар 64 баганат танхимд асар олон тоотой, том жижиг бурхны хөрөг баримал, олон зуун мянган цац нэг дор бөөнөөр байсан нь тэр хэвээрээ олдсон байна. Тухайлбал, Их танхимыг бүрэн хэмжээгээр малтаж гаргасны эцэст бүртгэн баримтжуулсан 17000 гаруй олдворын гуравны хоёроос илүү хувь нь буддын шашны холбогдолтой олдворууд байв.

Төрөл бүрийн органик үлдэгдлүүдэд хийсэн C_{14} -ийн шинжилгээ ба термолюминесценцийн судалгааны үр дүнд гарсан байгалийн шинжлэх ухааны он цаг ихэнхдээ XIII-XIV зуун гэж гарсан нь цаг хугацааны хувьд түүхийн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэн он цагтай яв цав нийцэж байжээ. Ийнхүү түүх, археологийн харьцуулсан судалгаагаар Хархорумын “Их танхим” нь үүрэг зориулалт ба ашиглалтын хувьд бүхэлдээ буддын сүм байсан нь тодорхой нотлогдохын зэрэгцээ хамгийн сүүлд явуулсан малтлагаар уг барилга 1346 оны Хархорумын бичээст дурдсан “Юань улсыг мандуулах асар” мөн болохыг улам баталж өгсөн байна.



Цогт их асар сүмийн баганы суурь

Монголын эзэнт гүрний нийслэл Хархорумд байсан буддын шашны Их сүмийн археологийн үлдэцийг хамгаалах ба ил музей болгох төслийг Германы талаас хэрэгжүүлж 2015 онд нээсэн юм.

